

# ХҮНИЙ ЭРХИЙН ТОО БАРИМТ 2014 ОНД

2014 онд Эмнэсти Интернэшнл дэлхийн **160** орны хүний эрхийн зөрчлийг шалгаж, баримтжууллаа. Зарим улсад дэвшил гарч байгаа ч олон хүний хувьд хүний эрхийн нөхцөл улам дордоор байна.



Дайны гэмт хэрэг, дайны эрх зүйтэй холбоотой бусад зөрчлүүд наанадаж **18** улсад гарчээ.



Наад зах нь **35** оронд зэвсэгт бүлэглэлүүд зөрчил үйлдсэн ба, тэдний 20%-д Эмнэсти Интернэшнл хүний эрхийн зөрчлийг шалгалаа.




**3,400**

**3400** гаруй хүн Европт хүрэх замдаа Газар дундын тэнгист живжээ.

**4,000,000**

**4 сая** хүн Сири улсад гарч буй мөргөлдөөнөөс дүрвэж,




**95%** нь хөрш орнуудад орогонохжээ.

# 62

**62** улс ердөө эрх, эрх чөлөөгөө эдэлснийх нь төлөө хүнийг үзэл санааны хоригдол болгон шоронд түгжлээ.



Улс орнуудын **17.5%** буюу **28** нь эмэгтэйчүүд амь нас, эрүүл мэндээрээ хохирох болон хүчингийн гэмт хэргийн золиос болохыг үл харгалzan үр хөндөлтийг бүрэн хориглосон хуультай байна.<sup>1</sup>



Улс орнуудын **58%** буюу **93** нь шударга бусаар шүүжээ. Шударга бус шүүх яллагдагч, гэмт хэргийн хохирогч эсвэл олон нийтэд шударга үнэнийг олгодоггүй.

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрхийн хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг

# 4 -НИЙ 3

Улс орнуудын дөрөвний гурав буюу **119** нь үзэл бодлоо илэрхийлэхийг дур мэдэн хязгаарлав. Олон улс оронд сонины газрыг хаах, сэтгүүлчдийг сүрдүүлэх зэргээр хэвлэлийн эрх чөлөөг боожээ.



Насанд хүрэгчдийн хоорондоо зөвшилцсөн ижил хүйсний бэлгийн харьцааг **78** улс хуулиараа гэмт хэрэгт тооцжээ.<sup>2</sup>



Улс орнуудын **82%** буюу **131** нь хүмүүсийг эрүүдэн шүүж, зүй бус харьцжээ.

\*Энэ баримтын статистик мэдээлэл нь бүх улсыг хамраагүй бөгөөд Эмнести Интернэшнлээс 2014 онд гарсан хүний эрхийн зөрчлийн талаар баттай эх сурвалжаас олж авсан мэдээлэл, баримтжуулалт хийсэн 160 оронд хамаарна.

<sup>1</sup>Нэхэн үргижүйн эрхийн төлөө төвийн мэдээлснээр.

<sup>2</sup> Олон улсын Лесбиян, Гей, Бисексуал, Транс, Интерсекс хүмүүсийн Нийгэмлэгийн мэдээлснээр.

Индекс: POL 10/002/2015  
2015 оны 2 дугаар сар

Эмнести Интернэшнл  
ОУНБДНГ  
Петер Бененсоны Байр  
1 Ийстон гудамж, Лондон WC1X 0DW  
Их Британи

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**

